



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 10 өдөр

Дугаар Н/505

Улаанбаатар хот


Үнэлгээний баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам” батлах тухай 38 дугаар тогтоол, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын хөдөлмөрийн дотоод журмын 5 дахь зүйлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын төрийн албан хаагчдын 2019 оны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх “Үнэлгээний баг”-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх удирдамжийг хоёрдугаар, дүгнэлтийн хуудсыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хэлтэс, албан хаагчдын гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин, гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрхэн биелүүлсэн эсэхийг журмын дагуу үнэлж дүгнэн, Үнэлгээний хуудсаар баталгаажуулан танилцуулахыг Үнэлгээний баг /Д.Төмөрбаатар, Д.Рэнцэнбямба/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Тушаал-2019

115050001450

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 201᠑ оны 1᠒ дугаар сарын
10...-ны өдрийн ᠗/᠕᠖ тушаалын нэгдүгээр хавсралт

Үнэлгээний багийн бүрэлдэхүүн

Үнэлгээний багийн ахлагч:

Д.Төмөрбаатар Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч

Д.Рэнцэнбямба Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч

Гишүүд:

А.Мөнгөн Захиргаа санхүүгийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч

С.Ариунжаргал Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч

Д.Итгэл Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн дарга

М.Мандах Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Н.Золжаргал Захиргаа санхүүгийн хэлтсийн ахлах, хүний нөөцийн мэргэжилтэн

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТЫН ГАЗРЫН ХЭЛТЭС, АЛБАН ХААГЧДЫН 2019 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮНТЭЙ ТАНИЛЦАЖ, ҮНЭЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

1. Үнэлгээний ажлын зорилго:

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэн 2019 онд тавьсан зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрхэн биелүүлж байгаатай танилцан, дүгнэлт гарган байгууллагын удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулах.

2. Тайлан сонсож, дүгнэх хугацаа:

Тайлантай 2019 оны 12 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд танилцаж, үнэлгээний дүнг 12 дугаар сарын 15-ны дотор газрын даргад танилцуулна.

3. Дүгнэх ажил:

а/ Тайлангаа танилцуулж, дүгнүүлэх ажиллагаанд Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын 4 хэлтсийн албан хаагчид хамрагдах бөгөөд үнэлгээний багийн бүрэлдэхүүнийг баталсан тушаал, удирдамжийг үнэлгээний ажил явагдахаас 3-5 хоногийн өмнө хүргүүлж, бэлтгэх бололцоог хангана.

б/ Хэлтэс, албан хаагчдын 2019 оны ажлын үр дүнг Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил үйлчилгээний үр дүн /ажлын тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, албан бичгийн шийдвэрлэлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт/, Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, Хандлага, зан үйлийн үнэлгээ-1 /ажлын цаг ашиглалт, үүрэг даалгаврын биелэлт, багаар ажиллах чадвар/ Хандлага зан үйлийн хамт олны үнэлгээ-2 /хэлтэс, нэгжийн хамт олны нууц санал хураалтаар/ гэсэн 4 чиглэл бүхий асуудлын хүрээнд холбогдох шалгуур үзүүлэлтээр, үзүүлэлт бүрийн гүйцэтгэлийг 100 хувиар дүйцүүлэн дүгнэнэ.

в/ "Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил үйлчилгээний үр дүн"-ийн чиглэлд хамаарагдах шалгуур үзүүлэлтийн авбал зохих хувь нь 100,

г/ "Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт"-ын чиглэлд хамаарагдах шалгуур үзүүлэлтийн авбал зохих хувь оноо 100,

д/ "Хандлага, зан үйлийн үнэлгээ-1"-ын чиглэлд хамаарагдах шалгуур үзүүлэлтийн авбал зохих хувь 100,

е/ “Хандлага, зан үйлийн үнэлгээ-2”-ын чиглэлд хамаарагдах шалгуур үзүүлэлтийн авбал зохих хувь нь 100 байна.

4. Үнэлгээний дүнг нэгтгэн танилцуулах:

а/ Дүнг гаргахдаа удирдамжийн хавсралт хүснэгтийн дагуу, дүгнэж буй шалгуур үзүүлэлтэд Үнэлгээний багийн гишүүдийн өгсөн гүйцэтгэлийн хувь түүнд дүйцэх онооны нийлбэрийн дунджаар гаргана.

б/ Үнэлгээ явуулсан баг ажлын дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж , хэлтэс, албан хаагчдын авсан оноогоор нь байр эзлүүлэн илтгэх хуудсаар байгууллагын дарга, Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулан шийдвэр гаргуулна.

ҮНЭЛГЭЭНИЙ БАГ